



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Зөвшөөрөл түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 7.7.4, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай А/17 тоот тушаалын нэгдүгээр хавсралтын нэгдүгээр аж ахуйн нэгж болох Хандү ХХК-ийн Хандү зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгосугай.

2. Энэхүү шийдвэрийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газарт хүргүүлж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай

ДАРГА

С.БАТБААТАР



1150500004